БЮБЦТС ТӨХК

# БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/68 Улаанбаатар хот

## Авлигын эсрэг төлөвлөгөө батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12, 6.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батални сугай.

2.Компанийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга (Я.Отгонзул)-д даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2024 оны 03 дугаар сарын 29-ий өдрийн А/98 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
2725010002 ж 2008904

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.ГАНЧУЛУУН

121250705

Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн А/68 дугаар тушаалын хавсралт

БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 03 дугаар сарын 21 Багануур дүүрэг

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хариуцах эзэн | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| | **Зорилт 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | |
| 1. | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг<br>а/байгууллагын албан ёсны цахим хуудас;<br>б/сошиал сувгууд;<br>в/дотоод сүлжээ;<br>г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл,<br>д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц,<br>е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | | Байршуулсан мэдээллийн тоо, түгээсэн суваг, давтамж, хандалтын тоо | -Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулж тайланд нотломжийг хавсаргасан байна.<br>-Цахим хуудас, сошиал сувгуудад тус бүр 50-аас доошгүй мэдээллийг оруулсан байна. | Мэдээлэл технологий алба /Маркетинг, мэдээллийн мэргэжилтэн Б.Солонго, ЭБАТ Б.Шинэтуяа/ | Жилдээ |
| 2. | 1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүй, залуусыг авлигын эсрэг оролцоотой, зөв, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд түгээх; | | а/ Бүтээсэн видео контентын тоо,<br>б/ Бүтээсэн контентын хандалтын тоо | - Авлигын эрсдэлээс ангид байх, ёс зүй, залуусыг авлигын эсрэг оролцоотой, зөв, шударга байдлыг уриалсан видео контент бүтээнэ.<br>- Бүтээсэн контент 30,000-аас доошгүй үзэлттэй байх; | Захиргаа хүний нөөцийн хэлтэс /ЭБАТ Б.Шинэтуяа/ | I-II улирал |
| 3. | 1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг | | | | Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс /Хэрэглэгч, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэвлэмэл материал зэрэгт шүгэл үлээхийг уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг сурталчлах; | Хэвлүүлсэн зурагт хуудас, сэтгүүл, хэвлэмэл материалын тоо | Байгууллага бүр 1 хэвлэмэл материалд шүгэл үлээхийг уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан байна. | гэрээ хариуцсан инженер Б.Базаргочоо, Харьяа салбарын хангах үйл ажиллагаа хариуцсан менежерүүд/ | Жилдээ |
| 4. | 1.4. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй аян, соён гэгээрүүлэх арга хэмжээг хариуцсан салбарын хэмжээнд зохион байгуулах; | - Зохион байгуулсан аяны тоо;<br>- Аянд нэгдүүлсэн хүн, хуулийн этгээдийн тоо<br>- АТГ-аас өгсөн чиглэл, зөвлөмжийг баримталсан байх;<br>- Зориулж бүтээсэн, түгээсэн контент, ном, гарын авлага, бусад | - Яамнаас нэгдсэн байдлаар 2 аяныг удирдан зохион байгуулж, харьяа байгууллага бүр аянд нэгдэж, аяныг дэмжиж ажиллана.<br>- Аян тус бүрт иргэд, олон нийтийг аянд нэгдүүлж, оролцоог хангуулсан байна.<br>- Аянд зориулж, 3-аас доошгүй сурталчилгааны материал /контент, зурагт хуудас, ном, гарын авлага, шторк г.м/ шинээр бэлтгэж, түгээж, түгээлтийн бүртгэлийг хөтөлж, нэгтгэн тайлагнасан байна. | Захиргаа хүний нөөцийн хэлтэс /ЭБАТ Б.Шинэтуяа/ | Тухай бүр |
| **Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх** | | | | | |
| 5. | 2.1. Төрийн байгууллага болон иргэн, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; | - Хамтран ажилласан үйл ажиллагааны тоо<br>- Хамтран ажиллах төлөвлөгөө баталсан байх; | Иргэн, иргэний нийгмийн байгууллагыг 2-оос багагүй үйл ажиллагаанд оролцуулж, хамтран ажилласан байна. | Захиргаа хүний нөөцийн хэлтэс /ЭБАТ Б.Шинэтуяа/ | Жилдээ |
| 6. | 2.2. Байгууллагын цахим хуудсанд дүн шинжилгээ хийж, мэдээллийг ил тод байдлыг хангаж ажиллах; | - Засгийн газрын 2022 оны 353 дугаар тогтоолыг баримталсан байх;<br>- Байршуулбал зохих мэдээллийн тоо | - Мэдээлбэл зохих бүх мэдээллийг байршуулж ажиллана. | Мэдээлэл технологийн алба /МТА-ны дарга, маркетинг мэдээллийн ажилтан/ | I-II улирал |
| 7. | 2.3. Компани, харьяа салбарын авлигаас урьдчилан сэргийлэх мэдээллийн самбарт холбогдох мэдээллийг шинэчлэн байршуулах | -компани, салбаруудын мэдээллийн самбарыг тогтмол мэдээллийг шинэчлэх, сонирхсон этгээдийг мэдээлэл авах боломжоор хангах | -мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж ажиллана. | Салбарын хүний нөөцийн мэргэжилтнүүд, компанийн ЭБАТ Б.Шинэтуяа | Тухай бүр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8. | 2.4. Компанийн хэмжээнд зохион байгуулах нээлттэй хаалганы өдөрлөг болон томоохон хэрэглэгчтэй хийх уулзалтаар авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах. | -хэрэглэгчийн уулзалт, өдөрлөг зохион байгуулахад авлигын эсрэг үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах. | -компанийн авлигын эсрэг үйл ажиллагааг нийтэд мэдээллэж, сурталчлах, | Харьяа салбарын Хангах үйл ажиллагаа хариуцсан менежер, ЭБАТ Б.Шинэтуяа | Тухай бүр |
| **Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах** | | | | | |
| 8. | 3.1. Компанийн удирдах болон эрх бүхий албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад 2-оос доошгүй удаа хамруулах | -АТГ болон бусад байгууллагаас авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа өөрийн байгууллагад авч, холбогдох албан тушаалтнуудыг хамруулах | -Авлигатай тэмцэх газар, бусад эрх бүхий байгууллагуудаас зохион байгуулж буй онлайн болон танхимын сургалтуудад холбогдох ажилтнуудыг бүрэн хамруулах | Сургалтын инженер Р.Ганхуяг, ЭБАТ Б.Шинэтуяа | I,IV улирал |
| 9. | 3.2. АТГ-аас ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | -АТГ болон эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд тайлагнах | -Авлигтай тэмцэх газар, холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авч ажиллах. | Захиргаа хүний нөөцийн хэлтэс /ЭБАТ Б.Шинэтуяа/ | Тухай бүр |
| 10. | 3.3. Компаниас зохион байгуулж буй тендерээр шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахдаа авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүссэн тохиолдолд мэдэгдэх зохицуулалтыг тусгах. | -худалдан авах ажиллагаатай холбоотой байгуулж буй гэрээнүүдэд авлига ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд компанид мэдэгдэх зохицуулалтыг тусгах. | -Компанийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж буй тендерт шалгарсан оролцогчтой худалдах худалдан авах, ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээний гэрээнүүдэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдлыг компанид мэдээлэх талаар зохицуулалтыг гэрээнд тусгаж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх. | Худалдан авах ажиллагаа хангамжийн алба /Албаны дарга Б.Гүррагчаа, ЭБАТ Б.Шинэтуяа/ | Тухай бүр |
| 11. | 3.4. Шинээр компанийн удирдах болон эрх бүхий албан тушаалд томилогдож буй албан тушаалтнуудад ажлын байрны анхан шатны | - Шинээр ажилд томилогдсон ажилтнуудад | - Шинээр томилогдсон удирдах болон эрх бүхий албан тушаалтнуудад | Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтэс | Тухай бүр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зааварчилгаа өгөхдөө авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зааварчилгаа өгч ажилд оруулах. | зааварчилгааг холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллах талаарх зааварчилгааг өгөх. | холбогдох зааварчилгаа өгч, ажилд нь оруулах. | /Хэлтсийн ахлах, ХАБЭАИ Д.Цэцгээ/ | |